

ЗАНАБАЗАРЫН НАМТАР ДАХЬ ТҮҮХИЙН ЗАРИМ МЭДЭЭ

Ш. Сонинбаяр

Төвд хэлээр байгаа Өндөр гэгээн Занабазарын намтруудын дотор Монголын түүх соёлд холбогдох мэдээ сэлт нилээд арвин гарч байгаа юм. Түүхэнд холбогдолтой зүйлийн дотроос Хүрэн билчирийн чуулган болон Халх, Ойрадын дайны шалтгааны тухай Өндөр гэгээний намтруудад хэрхэн өгүүлснийг дурьдахын зэрэгцээ төвд намтруудын талаар товч өгүүлэх болно.

1. Халхын Заябандид Лувсанпэрэнлэйн 1702 онд зохиосон «Гүн агуу их дээдийн номыг хүртэсний тэмдэглэл гэгээн толь»¹ хэмээх зохиолын 4-р ботид байгаа Өндөр гэгээний намтар бол Монголын эрдэмтдээс зохиосон Өндөр гэгээний анхны намтар бөгөөд хойших үеийн намтрууд зохиогдон гарахад үндсэн тулгуур сурвалж болж өгчээ. Энэ намтрыг «Лувсандамбийжанцангийн арван таван үеийн цэдэг тууж»² гэх буюу төвдөөр ном зохиол үздэг эрдэмтдийн дунд «ял-дав жо-аа» гэдэг нэрээрээ үлэмж дэлгэрсэн байдаг. Зая бандид Лувсанпэрэнлэй (1642—1715) бол шашин номын үйлсэд Өндөр гэгээнтэй хамтран зүтгэгч дотны нь шавь байсны хувьд түүний намтрыг зохиосон байна. Зая бандид Лувсанпэрэнлэй нь 1660—1679 оны хооронд Төвдөд очиж сургууль хийсэн тул тэрхүү 19 жилийн мэдээ баримтыг орхисны дээр өндөр гэгээнээс өмнө 1715 онд таалал төгссөн учир Өндөр гэгээний сүүлчийн жилүүдийн үйл явдал бичигдээгүй болно.

Зая бандидын намтарт «Хүрэн бэлчирийн чуулганы» тухай өгүүлэхдээ: «Гал барс (1689) жилийн намар Төвдөөс Далай ламын бие элч Гандан ширээт Агваанлодойжамц, Манжийн хааны элч Арни Али хан амбан нарыг илгээж халхын 7 хошуу хүрэн бэлчир гэдэг газар чуулган нийлэхэд Энх Амгалан хаан өөрийн элч Ачит цоржийг өндөр гэгээнд илгээж уг чуулганд голлон оролцохыг айлтгасан бөгөөд тус чуулган дээр Өндөр гэгээн нь Гандан ширээттэй адил суудалд зэрэгцэн сууж харилцан зөвлөлдөн Далай лам, Манжийн хааны зарлиг бичгийг зарлан тунхаглаж нэг сар гаруй хугацаанд Өндөр гэгээний зарлигийн түшмэл Дарва хийдийн лам Бандид цорж, Цэцэн нансо, Намжил тойн болон Халхын 3 хаад, голлосон 7 хошууны их лам, ноёд түшмэд 60 гаруй хүн оролцов гэж бичжээ. Энд гарч байгаа Дарва хийдийн Бандид цорж бол Өндөр гэгээний шадар шавь Дарва бандид Совдхамц (1637—1702) мөн болно. Мөн намтарт Галдан бошигтын тухай өгүүлэхдээ: «Галдан бошигт хан Өндөр гэгээнд чи Гандан ширээтэд мөргөл хүндлэл үйлдээгүй учир юун?» гэх зэрэг доромжилсон үгтэй захиа явуулсныг Түшээт хан зэрэг ноёд мэдээд хилэгнэн дургүйцэж 7 хошуунаас цэрэг дайчлан мордож Засагтхан, Дайчин хун тайж хоёрыг барьсан байна. Галдан бошогт Халхын баруун Урианхайн зарим ноёдыг уулгалан дайрсан зэрэг учирт Галданы дүү бага ноён Доржжавыг нөхөдтэй нь устгажээ. Энэ үед Төвдийн засгийн газраас Далай ламын элч Жалмядагтан хийдийн хамбыг Халх, Ойра-

1 zab dang rgya che ba' i dam pa' i chos kyi gsan yig gsal pa' i me long

2 blo bzang bstan pa' i rgyal mtsan dpalbzang po' i 'Krungrabs bco Inga" i rnam thar Бээжин бар 50-р тал

дын мөргөлдөөнийг эвлэрүүлэхээр явуулж ятгасан учир Түшээт хан зэрэг Халхын ноёдын удирдсан цэрэг тарж харьцгаажээ. Луу жилийн (1688) 2-р сард Галдан нутгаасаа цэрэг удирдан гарч Халхын баруун Илжигэн гэдэг 2-р хошуугаар дамжин Халхын нутгийн гүнд орж эрдэнэ зуу зэрэг хийдийг эвдэн сүйтгэх үед Өндөр гэгээн зүүн тийш зам буруулан зайлж Халхын зүүн Урианхай нутагт хүрсэн байна.

2. Их Хүрээний Түвдэн рабжамба «Занабазарын намтар сайн хувь таны сүсгийн тэрэг»³ гэдэг зохиолоо Зая бандидын зохиосон намтрыг түшиглэн манж монгол тэмдэглэл, бусад холбогдох материалыг үзэн судалж 1839 онд зохиожээ. Энэ намтар бол Зая бандидын зохиосон намтрыг дэлгэрүүлсний гадна Өндөр гэгээний зохиолоос иш татсан зүйл нилээд байна.

Түвдэн рабжамбын намтарт «Хүрэн бэлчирийн чуулган»-ны тухай бичихдээ Зая бандидын хэлсэн дээр зарим зүйлийг тодруулж өгсөн зүйл байгаа юм. Жишээ нь 5-р Далай ламын элч Гандан ширээтэд бараа болж Амдоогоос Жанжаа хутагт 1 Агваанлуvsанчойндон ирж оролцсон, Манжийн хаанаас Өндөр гэгээнд явуулсан элч Ачит цоржийн нэрийг Лувсанчоймбол гэж тодруулжээ. Мөн Хүрэн бэлчирийн чуулганыг Халхын 7 хошууны ноёд Ойрадын эрх баригчдын хооронд болсон гэдгийг тодруулан дурдсан байна. Хүрэн бэлчирийн чуулганд Ихэс лам нараас Ламын гэгээн Лувсанданзанжанцан, Зая бандид Лувсанпэрэнлэй нар оролцсоныг тэмдэглэжээ. Галдан бошигтын халхыг довтолсон тухай бол Зая бандидын хэлсэнтэй адилаvтар боловч Өндөр гэгээн Галдан бошигтоос буруулан ламын гэгээн зэрэг 100 гаруй бараа бологчдын хамт нууцаар зайлан гарсныг дурджээ. Энэ намтарт Халх, Ойрад хоёрын өвөг Очир хаанаас эхлээд Өндөр гэгээний үеийг хүртэл 9 удаагийн өс хонзонг амирлуулахын тухайд «Жинлав цогзол» гэдэг номыг Өндөр гэгээн зохиосныг тэмдэглэжээ. Энд гарч байгаа өвөг Очир хан гэдэг нь Өндөр гэгээний өвөг эцэг Эрхий мэргэн ханы эцэг болох Автай сайн хааныг хэлсэн байж болох юм. Яагаад гэвэл Халхын Автай сайн хаан, Далай лам Содномжамцтай уулзахад Далай ламаас Очир (Дорж) хаан гэж цол өргөмжлөн шагнаж байсан нь хожим Очирай Түшээт хан гэж үе дамжин хэрэглэгдсэн бололтой.

3. Их хүрээний дархан цорж Агваанлуvsандондовын зохиосон «За набазарын намтар хувь төгст нирвааныг хүсэгчдийн горилыг хангах баяр хурим»⁵ гэдэг намтар бол холбогдох түүхэн он цагийг нарийвч» лан гаргасны дээр монгол намтарт гардаг ид шид, домгийн зүйлс нилээд гарч байна. Дархан цорж намтартаа 8-р богд Живзүндамбыг 1874 онд төвдөөс авчирч ширээнд суулгасан үеийг дурдсанаас үзэхэд 1874 оноос хойно зохиосон бололтой.

Хүрэн бэлчирийн чуулганы талаар урьдах намтруудтай адилхан байна. Харин Түвдэнрамжамбын дурдсан Халх, Ойрадын 9 үеийн тэмцлийн талаар бол Энх Амгалан хааны 12-р он усан үхэр (1673) жилээс эхэлсэн 9 үеийн самуун тэмцлийг арилгахын тухайд Жинлав Цогзол гэдэг ном зохиож түүнд «Цагийг тохинуулагч залбирал»⁶ гэж

3 rje btzun dam pa blo bzang bstan pa' i rgyal mtsan gyi skal bzang dad pa" i shing rta Хүрээ бар 12-р тал

4 bvin rlabs mchogstzol

5 blo bzang bstan pa' i rgyal mtsan dpal bzang po' i rnam ldan dod pc basiskong dga stoi Хүрээ бар 86-р тал

6 dus bstan gsol 'debs

нэр өгсөн учрыг цаг төрийн байдалтай холбоотой юм гэжээ. Үүнээс үзэхэд Түвдэн Рабжамбын дурдсан өвөг Очир хааны үеэс эхэлсэн 9 үеийн тэмцлийн талаар он цагийн хувьд нилээд зөрөөтэй юм шиг санагдана. Галдан бошигтын тухай бичихдээ: «12-р жарны луу (1688) жилийн 2-р сард Галдан нутгаасаа цэрэг аван Халхад довтолж нутгийн гүнд цөмрөн орж 1689, 1690 онуудад Өндөр гэгээн бараа бологчдын хамт Галданы довтолгооноос буруулж Орхон голыг өгсөн Жанчитаар дайрч зүүн тийш эргэн Ерөөгийн рашаан, Шарлин голоор дайран Сарьдагийн нуруу, Аяагийн гол, Хагын хар нуур зэрэг газруу даар бүгэн явсаар Хэрлэнгийн Баян улаанд бүгж байгаад Авга Сөнөдийн нутагт гарсан» гэжээ. Үүнээс харахад Өндөр гэгээний буруулан зайлсан замын газар усны нэрүүдийг тодруулан өгсөн зэрэг нь судалгаанд ач холбогдолтой юм.

4. «Занабазарын намтар сайн хувьтаны чихний чимэг»⁷ гэдэг зохиогч нь үл мэдэгдэх төвд гар бичмэл намтар нь доторхи агуулга үг утгын хувьд дээр дурдсан Дархан цоржийн намтартай яг ижилхэн байгаа боловч Өндөр гэгээний зохиолуудын гарчигийг оруулаагүй жижигхэн зөрөө байгаа юм. Энэ намтар нь Дархан цоржийн зохиосон өөр нэг хувилбар бололтой. Энэ намтарт Хүрэн бэлчирийн чуулган, Галдан Халхад довтолж Өндөр гэгээний буруулан явсан газар усны нэр дээрх намтартай яг мөргөж байгаа юм.

5. Говь мэргэн вангийн хошууны Баян овоо хийдийн цорж Дагважамцын 1912 онд зохиосон «Живзундамбын намтар магтаалын үг, сайн хувьтаны сүсгийг сэргээгч»⁸ гэдэг намтар бол Өндөр гэгээний үйл амьдралыг 13 бүлэгт багтаан гаргахдаа бусад намтрууд шиг үргэлжилсэн үгээр бичилгүй төвдийн өлмий тэнцүүлэх гэдэг шүлэглэх зарчмын дагуу маш чадамгай сайхан холбон бичсэн юм. Энэ намтарт Хүрэн бэлчирийн чуулган, Галданы халхад довтолсон тухай бусад намтруудтай адил байгаа боловч Хүрэн бэлчирийн чуулганд ирж оролцсон Далай ламын элч Гандан ширээт Агваанлодойжамцыг 44-р ширээт гэж тодруулжээ. Энэ нь Төвдийн Гандан хийдийг үндэслэгч Зонховаас хойш дараалан суусан 44-р ширээт юм. Мөн энд гал хулгана (1696) жил Өндөр гэгээн Халх, Ойрадын дайн хямралыг намжаахын тулд Жинлавцогзолыг зохиосон юм.

Аливаа дайн дажны эсрэг хүн ардын энх амгаланг мөрөөдсөн Нэгэн бадгийг орчуулъя.

Атгагт муу нисваанисын⁹ үр цагтаа боловсорсон
Аливаа зовлонгийн их гал бүхнийг амирлуулаад
Алалдан тэмцэх өс хонзонг асрал энэрлээр зохицуулж
Амгалан энхийн хотол чуулганыг дэлгэрүүлэн соёрх! гэжээ.

6. Сайн ноён хан аймгийн Хошууч бэйсийн хошууны Агваанпэрэнлэйжамцын 1915 онд зохиосон «Богд Агваанлуvsанчойжиннямданзанваанчигийн олон дүрүүдийн намтар эндүүрлийн үзэгдлийг машинд тодруулагч шашин төрийн наран саран хосолсон гэгээн гэрэл»¹⁰

7 blo bzang bstan pa' i rgyal mtsandpal bzang po' i rnam thar skal bzang rna pa i bcud len бичмэл 86-р тал

8 rje btzun dam pa rin po chi' i rnam thar bstod tseg skal bzang dad gsos Түвдандоржайлин хийдийн бар 118-р тал
9 Зовлон зовоох гэсэн утгатай самгарьд үг, ни-мон (төвдөөр) гэдэг аливаа зовлонгийн үндэс болдог мунхаг, уурлах, тачаал зэрэг сэтгэлүүдийг нисваанис гэнэ.

10 rje btzun dam pa Ta ra na tha gang gi mchog sprul ngag dbang dlo bzang chos kyi nyi ma bstandzin dbang phyug dpal bzang po' i sku 'phring so so' i rnam thar dang rgyal pa nams lung bstan dang rgyal rabs kyi tsul gsal bar byed pa "khul snang rab gsal chos srid nyi zla zug gi od kyi snang ba бичмэл 188-р тал

гэдэг зохиол нь угтаа 8-р Богдын намтрыг голлосон боловч Өндөр гэгээнээс хойших богдуудын намтрыг гаргаад Монгол хаадын угсаа дараалал Монголын шашин түүхийг тусгайд нь нэг бүлэг болгон бичсэнээс үзэхэд дан намтар бус түүхэн зохиолын чанартай юм. Энэ зохиолыг Богд хаант улсын үед монголоор орчуулж 2 дэвтэр болгон¹¹ хэвлэсэн байдаг. Энэ зохиолын доторхи Өндөр гэгээний намтарт Хүрэн бэлчрийн чуулганы талаар дурдаагүй байна. Галданы талаарх мэдээ нь таарч байна. Галдан бошигтыг Төвдийн I банчин ламын хэлснээр Хайдүв Санжай Иш гэдэг эрдэмтэй ламын Хойд дүр гэсэн мэдээг оруулсан байна.

7. Түшээт хан аймгийн Түшээт ханы хошууны Агваанцүлтэмжамцын 1925 онд зохиосон «Живзундамбын удаа дараалан заларсны намтрыг товчлон хураангуйлж өгүүлсэн сүсэг төгстөн бүгдийг баясагч үзэсгэлэнт чимэг¹² гэдэг зохиолдоо гал барс (1686) жилийн намтар болсон «Хүрэн бэлчрийн чуулганыг Халх, Ойрадын төрийг засахын тухайд болсон» гэж тэмдэглэжээ. Энэ чуулганд «Төвдийн Далай ламын элч Ти-жанагва ирж оролцсон» гэж бичсэн юм. Энэ Ти-жанагва бол Гандан ширээт Агваанлодойжамцын өөр нэг нэр юм. Дээрх 7 намтруудаас гадна түүхч Заваа Дамдингавж, Нанзадаграмба нарын түүхийн зохиолуудад Өндөр гэгээний намтар орсон байна.

8. Сэцэн ханы Нанзад аграмбын 1903 онд зохиосон түүхийн он дарааллын бичигт (Данзий)¹³ Хүрэн бэлчрийн чуулганы талаар дурдаагүй харин Гүүш (Төрбайх)¹⁴ хааны ач Даржаа жононгийн хүү Галдан бошигт гэдэг Өндөр гэгээнд Гандан ширээтийг хүндэлсэнгүй гэж дайрч доромжилсон бичиг илгээсэн» тухай дурдсан байна.

9. Монголын түүхч Заваа Дамдин гавжийн 1931 онд зохиосон «Монголд бурхан шашин дэлгэрсэн түүх»-д¹⁵ Өндөр гэгээний намтар нилээд дэлгэрэнгүй гарч байна. Хүрэн бэлчрийн чуулганыг Халх, Ойрадын хооронд болсныг тэмдэглээд Ойрадын Галдан бошигт хан Өндөр гэгээнийг тус чуулган дээр Гандан ширээттэй адил суудалд зэрэгцэн суусанд дургүйцэн «Живзундамба та Богд Зонхавын Ширээг залгасан Гандан ширээтээр ч зогсохгүй шашны эзэн Далай ламын төлөөний элчийг хүндэтгэн үзэлгүй адил суудалд зэрэгтэн суух чинь юу вэ?» гэсэн бичиг Өндөр гэгээнд явуулсныг тэмдэглэжээ. Заваа Дамдин энэ дашрамд Өөлдийн Галдан бошигтын талаар: Хар хул хааны 4-р хүү Баатар хун тайжид Гүүш хаан охиноо хатан болгож өгчээ. Тэр хатнаас төрсөн Сэнгэ, Галдан хоёр бөгөөд Галданг багад нь төвдийн энса хийдийн нэг ламын хувилгаан гэж Төвдөд явуулж сургууль хийлгэжээ. Төвдөд байхад нутагт нь самуун дэг-

11 «Гэтэлгэгч дээд дарнатын гэгээний дээд хувилгаан Агваанлуvsан чойжинням данзанваанчиг балсан буугын дүр дүрний түүх хийгээд лигуугсан нугуудын бошиг үзүүлсэн ба хааны угсаа ёсыг тодруулан үйлдсэн эндүүрлийн үзэгдлийг машид арилгагч шашин төрийн наран саран хосолсоны гэрлийн гэгээ хэмээгдэх оривой» 1916 он. Хорголжин бар. 2 дэвтэр. УННС,

12 rje btzum dam pa' i sku "phreng rim byon rnamс kyi rnam thar mdor bsdus su brjod pa dad hdan kun dga' i mdzes rgyan бичмэл 57-р тал

13 sangs rgyas kyi bstan pa' i gnas tsad bla ma gong ma' i sku phreng rim byon gdan rabs rgyal rabs rnamс nyung bsdus su bkod pa mig gi dga' ston Хүрээ бар 51-р тал

14 Гүүш хаан Төрбайх (1582 — 1654)-ыг түүхч Нанзад аграмбын он дараалалын бичигт Хошуудын Ханий ноёны хүү Төрбарих гэжээ.

15 "dzin gling byang phyogs chen po hor gyi rgyal khams kyi togs pa brjod pa'i bstan bcos dpyod ldan rgu byed ngo mtsar gser gyi deb ther Делийн хэвлэл 340-р тал

дэж ах Сэнгийн алагдсан мэдээ аваад 5-р Далай ламд санваараа буцаан өргөх үед Далай ламаас Бошигт цолоор шагнагдаад нутагтаа эргэж ирээд Ойрадын хан болж улмаар Халх болон Манжийн эсрэг дайтан тэмцсээр түүний дарагдсан хүртэлх үеийг товчхон гаргасан байна. Дээрхи намтруудаас үзэхэд 1686 оны Хүрэн бэлчирт болсон Халх, Ойрадын феодалуудын чуулган нь шууд Манжийн хааны нөлөөн дор явагдаж Халх, Ойрадын хурцадмал байдлыг түр намжаан Манж өөртөө ашигтай байдал олж авах гэсэн далдын бодлого явуулж байсныг БНМАУ-ын түүхийн дэд¹⁶ ботид тодорхой бичсэн байдаг. Хүрэн бэлчирийн чуулганаас шалтгаалж Галдан бошигт халхыг дайрсан учрыг заваа Дамдин гавьж дээр дурдсан зохиолд тусгай нэмэлт болгон зохиосон «Шастирын сүржан»¹⁷ гэдэг судартаа 4 үндсэн зүйл дээр тулгуурлан бичжээ. Энэ нь Живзүндамба хутагтыг Гандан ши рээтэд найр тавьсангүй хэмээсэн ба Түшээт хан Чахундоржийг Очирт ханд тусалж өөрийг байлдан явсан ба бас Чахундорж охиноо Очирг ханы ач Лувсангомборавданд гэргий болгон өгсөн, Чахундорж Галдан бошигтын дүү Доржжавыг алсан зэрэг 4 өшөөгөөр цэрэг байгуулж халхыг довтолсон гэжээ.

1686—1690 онуудад Халх, Ойрадын хооронд болсон зарим түүхэн үйл явдлыг Өндөр гэгээний намтруудад хэрхэн тусгасныг харьцуулж үзэхэд ийм байна.

ЯПОН ДАХЬ МОНГОЛЫН ЭРТ, ДУНДАД ЗУУНЫ ҮЕИЙН ТҮҮХ СУДЛАЛЫН ТУХАЙД

Т. Мөнхцэцэг

Японд Монголын эрт, дундад үеийн түүхийг 1900-гаад оны үеэс судлах болсон байна. Энэ судалгаанд юуны өмнө Монголын түүхийн сурвалж бичгийн судалгаа орно. Нака Мичиёо 1907 онд “Монголын нууц товчоо”-г орчуулж¹ нийтийн хүртээл болгосон нь монгол судлалын талаар Японд гарсан анхны дорвитой бүтээл болжээ. Үүний дараахи «Монголын нууц товчоо»-ны томоохон судалгаанд Т. Кобаяши, К. Шираторигийн орчуулга² орох юм. Чухамхүү энэ үеэс уг сурвалжийг хэл, түүх, уран зохиолын талаас судлах явдал өргөжиж түүхийн үүднээс нь К. Ширатори, Ш. Ивамура, М. Мураками, Ж. Ёшида нарын зэрэг олон судлаачид авч үзэх болсон бөгөөд үүнд монголчуудын гарал үүсэлтэй холбоотой домог, газар ус, хүний нэрийн судалгаа голлож байна.

¹⁶ БНМАУ-ын түүх. УБ., 1968. II дэвтэр

¹⁷ chen po hor gyi yul gru' i sngon rabs kyi brjed byang sästra'i zur rgyang du sog yig las bod skad du bsbyur te bkod pa Делийн хэвлэл 26—27-р тал,

¹ Нака Мичиёо Чингис хааны үнэн тэмдэглэл (Чингис хан жицүроку) Токио. Дайнихон тошё. 1907. Дахин 1943 онд хэвлэгдсэн. Чикума шёбо.

² Кобаяши Такаширо. Монголын нууц түүх. (Мооконо хиши) 1941. Токио. Сэйкапушя. , Ширатори Куракичи. Галигчилсан монголын нууц товчоо (Оняку Мообүн гэнчёо хиши) 1943. Тооёо бунко